

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР


“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ-2025” АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 16

Мөрөн сум

Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөлийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хэг/1122 тоот албан бичиг, удирдамжийн дагуу “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээг нээлттэй засгийн түншлэлийн үнэт зүйлийг бэхжүүлэхэд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, “И-бизнес” бизнес эрхлэгчдэд зориулсан платформыг танилцуулах зорилгоор Хөвсгөл аймагт 2025 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулахаар 5 арга хэмжээ төлөвлөсөн.

БАТЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА 
2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

УДИРДАМЖ

2025 оны 05 дугаар сарын 16

Мөрөн сум

“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025”
арга хэмжээ зохион байгуулах тухай

Зорилго:

Нээлттэй засгийн түншлэлийн үнэт зүйлсийг бэхжүүлэхэд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, И-бизнес платформыг таниулахад оршино.

Хамрах хүрээ:

- Төрийн байгууллагууд
- Бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага
- Иргэний нийгмийн байгууллага

Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 19-23-ны хооронд


Зохион байгуулах арга хэмжээ:

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Оролцогч	Үр дүн
1	Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах- богино шторк эсвэл рийл хийх	05.19	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Нээлттэй засгийн түншлэлийн тухай мэдлэг, ойлголттой болох
2	“И-бизнес” платформын цахим үйлчилгээний талаар танилцуулах	05.20	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	И-бизнес платформын талаарх ойлголтоо нэмэгдүүлэх
3	Сонгуулийн Ерөнхий хороотой хамтран “Нээлттэй засгийн сорилт: Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” арга хэмжээг зохион байгуулах	05.21	Улс төрийн намын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	Тайлангийн цахим системийн хөгжүүлэлт дээр хамтран ажиллах суурь тавигдах
4	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Бизнес ба хүний эрх” сургалтыг цахимаар зохион байгуулах	05.22	АЗДТГ, ИТХ удирдлага, мэргэжилтнүүд	НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын тухай мэдлэг, ойлголттой болох
5	Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны мэдээлэл солилцох уулзалт	05.23	ЗДТГ, Дэлхийн Зөн ОУБ, иргэний нийгмийн байгууллагууд	Иргэний нийгмийн байгууллага мэдээллээр хангагдах, хамтын ажиллагааны чиглэл тодорхойлогдох

оОо

ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

1. 2025 оны 05 сарын 19-ны өдөр Нээлттэй засгийн түншлэл санаачилгын хүрээнд “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд улс орон даяар зэрэг зохион байгуулагдаж байгаа тухай богино хэмжээний шторк бэлтгэж олон нийтэд хүргэсэн. Нийт 1300 иргэнд хүрсэн. <https://www.facebook.com/100083122512861/videos/9605832442875632>




2. Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран төрийн үйлчилгээг олон нийтэд нээлттэй танилцуулах, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, цахимаар авах үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор “Таны өмнө-Төрийн үйлчилгээ” аяныг зохион байгуулах төлөвлөгөө батлуулж, “И-бизнес” платформын цахим үйлчилгээний талаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд танилцуулах арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж өгсөн. Сарын аяны хүрээнд Хөвсгөл аймгийн бүх сумдад киоск машин хүлээлгэн өгч, тус машинаар аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Мөн төрийн байгууллагуудын нийтийн мэдээллийн ид тод байдлыг ханган ажиллах 123 мэргэжилтнүүдэд, онлайнаар 144 албан хаагчдад Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтарсан сургалтыг зохион байгуулсан. Аяны хүрээнд хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа-15, аж ауй нэгжийн үл хөдлөхийн лавлагаа-9, хуулийн этгээдийн нэр авсан-3, и-бизнес платформоос– 29 иргэн, аж ахуйн нэгж лавлагаа авах үйлчилгээнд хамрагдсан байна.



3. 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдөр Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног хөтөлбөрийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос бэлтгэн ирүүлсэн видео танилцуулгыг Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлж буй Монгол Ардын Нам,

Ардчилсан нам, Иргэний оролцооны нэгдэл намын төлөөллүүдэд хүргэж ажилласан.

4. 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан “Бизнес ба хүний эрх” онлайн сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны удирдлага, мэргэжилтнүүдээс бүрдсэн 18 оролцогч хамрагдаж бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд, Монгол Улсын Засгийн газраас 2023 онд баталсан 231 тоот тогтоол “Бизнес ба хүний эрхийн Үндэсний төлөвлөгөө, үүрэг хүлээгч талуудын үүрэг хариуцлага”-ын талаарх ойлголтоо нэмэгдүүлсэн.



5. 2025 оны 05 сарын дугаар 23-нд “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээний хаалтын өдрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн иргэдийн



Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Дэлхийн Зөн ОУБ-тай хамтран төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцох уулзалтыг "Иргэний танхим"-д зохион байгууллаа. Тус мэдээлэл солилцох

уулзалтад иргэний нийгмийн байгууллагын 20 орчим төлөөлөл оролцож аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтэс, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны



удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтсээс хамтын ажиллагааны мэдээлэл өгч, “Сайхан айл ТББ”-аас Сэлэнгэ аймагт ажилласан туршлагаа хуваалцлаа.

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА
2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

УДИРДАМЖ

2025 оны 05 сарын 16

Мөрөн сум

Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны мэдээлэл солилцох уулзалт

Зорилго: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцох

Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 09:00 цагт

Хаана: Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Иргэний танхим”

Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Дэлхийн зөн ОУБ

АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Цаг	Арга хэмжээ	Тайлбар
1	08:50-09:00	Бүртгэл	
2	09:00-09:20	Засаглал, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах чиглэл, үр дүн	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
3	09:20-09:40	АИТХ-ын хороод иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах боломж	АИТХ-ын ажлын алба
4	09:40-10:00	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангахад хамтран ажиллах санал	Хууль, эрх зүйн хэлтэс
5	10:00-10:30	Нийгмийн хамгааллын салбарын хамтын ажиллагаа Хөдөлмөр халамж, гэр бүл хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах боломж	Нийгмийн бодлогын хэлтэс
	10:40-11:00	Цайны завсарлага	Дэлхийн Зөн ОУБ
4	11:00-11:30	Дэлхийн Зөн ОУБ-аас мэдээлэл хийх Сэлэнгэ аймагт туршлага судалдсан ТББ-ын төлөөлөл мэдээлэл хуваалцах	Дэлхийн зөн
5	11:30-12:00	• “Эко мамми” ТББ-ийн туршлага хуваалцах мэдээлэл /Герман явсан болон төсөл хэрэгжүүлсэн талаар/	Эко мамми ТББ
6	12:00-13:00	Санал солилцох, хэлэлцүүлэг, чадавхжуулах сургалтын чиглэл тодорхойлох	Оролцогч талууд
	13:00-14:00	Үдийн хоол	Дэлхийн зөн

оОо

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНДЭЛГЭР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭНД-АЮУШ